| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **45,860,000.00** | **76,770,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 116,406,134.95 | 269,832,781.73 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 196,418,131.39 | 312,824,266.34 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 312,824,266.34 | 582,657,048.07 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,671,366,799.75 | 3,090,654,801.17 | 841,094,401.78 | 6,603,116,002.70 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (1,800,000.28) | (1,800,000.28) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,671,366,799.75** | **3,090,654,801.17** | **839,294,401.50** | **6,601,316,002.42** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 7,200,000.00 | | | 7,200,000.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 22,122,416,525.23 | 22,122,416,525.23 |
| C08 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,678,566,799.75** | **3,090,654,801.17** | **22,961,710,926.73** | **28,730,932,527.65** |
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,678,566,799.00** | **-** | **-** | **28,730,932,527.65** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (8,700,000.00) | (8,700,000.00) |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,678,566,799.75** | **3,090,654,801.17** | **22,953,010,926.73** | **28,722,232,527.65** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 1,352,635,010.82 | 1,352,635,010.82 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,678,566,799.75** | **3,090,654,801.17** | **24,305,645,937.55** | **30,074,867,538.47** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,921,730,700.00 | 2,609,123,358.11 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,250,833,300.00 | 2,171,385,999.11 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,222,346,500.00 | 2,146,238,149.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,521,655,700.00 | 1,497,572,129.90 |
| 210101 | Үндсэн цалин | 1,226,031,500.00 | 1,211,941,314.90 |
| 210102 | Нэмэгдэл | 204,391,700.00 | 195,526,939.00 |
| 210104 | Урамшуулал | 91,232,500.00 | 90,103,876.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 196,379,100.00 | 191,774,464.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 134,739,900.00 | 131,549,337.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,440,900.00 | 13,247,726.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,900,200.00 | 6,715,361.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,479,000.00 | 10,384,832.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 30,819,100.00 | 29,877,208.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 220,394,400.00 | 219,777,822.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 27,046,400.00 | 26,429,822.21 |
| 210302 | Түлш, халаалт | 181,733,200.00 | 181,733,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,614,800.00 | 11,614,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 68,127,700.00 | 67,886,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,126,400.00 | 7,126,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,918,900.00 | 38,918,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,505,700.00 | 4,465,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,436,300.00 | 2,275,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ар | 2,630,000.00 | 2,630,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,510,400.00 | 12,469,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 83,175,900.00 | 61,338,275.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,773,500.00 | 2,773,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 63,882,400.00 | 42,623,125.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 16,520,000.00 | 15,941,650.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,732,900.00 | 14,732,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,620,000.00 | 3,620,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,112,900.00 | 11,112,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,461,900.00 | 11,461,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,684,700.00 | 8,684,700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 2,777,200.00 | 2,777,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | 29,563,800.00 | 7,630,480.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгэ | 25,688,900.00 | 3,755,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,190,000.00 | 2,190,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 197,500.00 | 197,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,098,700.00 | 1,098,680.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | 176,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 212,700.00 | 212,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 76,855,100.00 | 74,063,978.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,445,100.00 | 69,653,978.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,410,000.00 | 4,410,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,486,800.00 | 25,147,850.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,486,800.00 | 25,147,850.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,303,100.00 | 12,964,150.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,183,700.00 | 12,183,700.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **550,897,400.00** | **360,967,359.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 550,897,400.00 | 360,967,359.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 550,897,400.00 | 360,967,359.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР З** | 120,000,000.00 | 76,770,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 120,000,000.00 | 76,770,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,921,730,700.00 | 2,835,583,934.11 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,349,917,700.00 | 1,298,343,772.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,349,917,700.00 | 1,298,343,772.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,129,576,800.00 | 1,104,768,949.11 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 826,729,600.00 | 801,921,749.11 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 302,847,200.00 | 302,847,200.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА** | 244,986,200.00 | 100,013,213.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,646,800.00 | 32,426,313.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 704,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 235,739,400.00 | 66,882,900.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 197,250,000.00 | 332,458,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 197,250,000.00 | 332,458,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **401,213,951.00** | **59,555,397.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **401,213,951.00** | **59,555,397.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 401,213,951.00 | 59,555,397.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,835,562.00 | 10,029,376.00 |
| 210101 | Үндсэн цалин | 787,562.00 | - |
| 210104 | Урамшуулал | 4,048,000.00 | 10,029,376.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,031,597.00 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,031,597.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,738,349.00 | 12,019,506.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 745,102.00 | 672,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,760,747.00 | 3,593,831.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 80,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 9,878,000.00 | 3,996,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 354,500.00 | 3,676,825.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,150,000.00 | 3,932,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,150,000.00 | 3,932,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,073,336.00 | 5,334,165.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,352,000.00 | 1,164,265.00 |
| 210602 | Тавилга | 2,480,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 16,241,336.00 | 4,169,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,381,000.00 | 1,903,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,381,000.00 | 1,903,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,485,499.00 | 1,460,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,485,499.00 | 1,460,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 335,518,608.00 | 24,876,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 335,518,608.00 | 24,876,250.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 401,213,952.00 | 59,555,397.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 401,213,952.00 | 59,555,397.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,299,422.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 345,481,933.00 | 39,236,997.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,432,597.00 | 20,318,400.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Х.Хүрэл-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-наас 2021 оны 03 дугаар сарын 24-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/146 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Халхгол сумын Засаг Даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 3,339,882.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 66,797.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,351,437.2 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 312,824.3 | 582,657.1 | 269,832.8 |
| Авлага | 149,199.8 | 194,876.7 | 45,676.9 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 519,881.1 | 608,549.5 | 88,668.4 |
| Үндсэн хөрөнгө | 27,749,138.9 | 28,696,397.9 | 947,259.0 |
| **Нийт хөрөнгө** | **28,731,044.1** | **30,082,481.3** | **1,351,437.2** |
| Өр төлбөр | 111.6 | 7,613.7 | 7,502.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 28,730,932.5 | 30,074,867.5 | 1.343,935.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **28,731,044.1** | **30,082,481.3** | **1,351,437.2** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 582,657.1 мянган төгрөг болж өмнөх оноос 269,832.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтын зарим ажлууд бүрэн хийгдээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 194,876.7 мянган төгрөг болж 45,676.9 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны орон нутаг хөгжүүлэх сангийн авлагаас авсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэл 194,876.7 мянган төгрөг нь төсөл сантай холбоотой хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 608,549.5 мянган төгрөг болж 88,668.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн байгууллагуудад Ерөнхий сайдын багцаас хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 28,696,397.9 мянган төгрөг болж 947,259.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн байгууллагуудад Ерөнхий сайдын багцаас хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 894,798.1 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 425.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 52,035.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 10,029,483.5 мянган төгрөг, акталсан 239,699.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 276,363.1 мянган төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,613.7 мянган төгрөг болж 7,502.1 мянган төгрөгөөр өссөн нь байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 30,074,867.5 мянган төгрөг болж 1.343,935.0 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 11,867,080.1 мянган төгрөгөөр буюу 45.0 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 263,275.7 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад болон үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,921,730.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,921,730.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс 2,921,730.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,921,730.7 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвөөс 2,479,494.5 мянган төгрөг, хандив тусламжаар 197,250.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 244,986.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,835,583.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,609,123.4 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 149,712.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 192,600.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 128.6 хувиар биелүүлсэн байна.

Сумын төсвийн орлого 42,887.9 мянган төгрөгөөр давсан нь газрын төлбөр, шууд бус орлого давж биелсэнтэй холбоотой байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 39,236.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20,317.5 мянга, нийт 59,554.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин, урамшуулалд 10,029.4 мянга, бараа материалын зардалд 12,019.5 мянга, норматив зардал-д 3,932.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 5,334.2 мянган төгрөг, томилолтын зардалд 1,903.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 26,336.1 мянган төгрөг, нийт 59,554.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 49 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна. Мөн түүвэрт хамрагдсан Халхгол нэгдэл ОНӨААН нь 57 нэр төрлийн 9,584233378 төгрөг 95 мөнгөний хөрөнгийн орлогыг, СХС-гаас олгосон 6 иргэнд олгосон 76,770,000 мянган төгрөгийн зээлийг тус тус www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0,1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 39,1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 25,4 мянган төгрөгийн 1зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 0,1 | 1 | 0,1 | - | - | - |
| Албан шаардлага | 1 | 39,1 | 1 | 39,1 | - | - | - |
| Зөвлөмж | 1 | 25,4 | 1 | 25,4 | - | - | - |
| **Нийт дүн** | **3** | **64,6** | **3** | **64,6** | **-** | **-** | **-** |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 82,756.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 82,618.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй 138.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар үйл ажиллагаатай холбоотой 82,618.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Сумын Засаг даргын захирамжаар нийт 6,500.0 мянган төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно" гэсэн заалтад нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан шаардлага хүргүүлэв.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 39.1 хувь нь буюу 76,118.4 мянган төгрөг нь хугацаа хэтэрсэн нь байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтад нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Албан шаардлага хүргүүлэв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 138.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Дотоод хяналттай холбоотой асуудал*

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>* ОНХС-гийн хөрөнгөөр 550,897.4 мянган төгрөгийн 18 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 138.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

*1.2.* *<u>Эрсдэл:</u>* Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрэх үр дүн хангагдахгүй байх.

*1.3.* *<u>Өгсөн зөвлөмж:</u>* Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

*<u>1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | |
|---|---|---|
| Огноо: 2020 | Аудитын нэр: ***Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: ДОА-2021/14/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | ***Халхгол сумын ТТЗ*** | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сумын Засаг даргын захирамжаар тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан. | 6,500.0 | Албан шаардлага хүргүүлэв. | Санхүүгийн албаны дарга | Б.Отгонтуяа |
| 2 | Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 39.1 хувь нь хугацаа хэтэрсэн нь байна | 76,118.4 | Албан шаардлага хүргүүлэв. | Санхүүгийн албаны дарга | Б.Отгонтуяа |
| 3 | ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 138.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаагүй байна | 138.0 | Зөвлөмж өгөв. | Санхүүгийн албаны дарга | Б.Отгонтуяа |
| 4 | Түүвэрт Халхгол нэгдэл ОНӨААН нь 57 нэр төрлийн 9,584,233,378 төгрөг 95 мөнгөний хөрөнгийн орлогыг, СХС-гаас олгосон 6 иргэнд олгосон 76,770,000 мянган төгрөгийн зээлийг тус тус www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна. | - | Албан шаардлага хүргүүлэв. | Санхүүгийн албаны дарга | Б.Отгонтуяа |
| **ДҮН** | | **82,756.4** | | | |